



**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2010 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 453

Улаанбаатар хот


Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 42/123/246 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
2. Дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Мэдээлэл, шуурхай удирдлагын төв /цагдаагийн хурандаа Ц.Батчулуун/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /цагдаагийн хурандаа Ц.Арвинбуудай/, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн газар /цагдаагийн хурандаа С.Баатаржав/-т тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаалыг 2010 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ


ХУУЛБАР ҮНЭН.
Захиргааны удирдлагын газрын
дарга, цагдаагийн хурандаа



Д.САНДАГ-ОЧИР

Ц.Арвинбуудай

092581



МЭДЭЭЛЭЛ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Мэдээлэл, шуурхай удирдлагын төв /Цаашид "Төв" гэх/-ийн чиг үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагааны нийтлэг зарчим, бүрэн эрх, бусад байгууллагатай харилцах хэм хэмжээг тодорхойлж, үйл ажиллагааг нь зохицуулахад оршино.

1.2. Төв нь Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас холбоо, мэдээллийн хэрэгсэл, бусад хэлбэрээр ирүүлж буй гэмт хэрэг, зөрчил, гамшиг, осол, гал түймэр, эмнэлгийн яаралтай тусламжийн талаарх мэдээллийг хүлээн авч, шуурхай удирдлага, зохицуулалтаар ханган, хяналт тавьж, мэдээ мэдээллийг боловсруулах, дээд шатны байгууллагуудыг мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага болно.

1.3. Төв нь үндсэн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Эрүүгийн байцаан шийтгэх, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Цагдаагийн байгууллагын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Эрүүл мэндийн багц хуулиуд, дээд байгууллагуудын шийдвэр болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

1.4. Төвийн үйл ажиллагаа нь хууль ёсыг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, иргэдтэй соёлтой харьцаж, шуурхай үйлчлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах сонор сэрэмжтэй байх төрийн албаны үндсэн зарчмуудыг мөрдлөг болгоно.

1.5. Төв нь тогтоосон журмын дагуу хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Төвийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Төв нь 24 цагийн турш тасралтгүй, холбоо, мэдээлэл, шуурхай удирдлагын үйл ажиллагааг хангахуйц мэргэшсэн төрийн тусгай алба хаагчид, инженер техникийн болон эмнэлгийн мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн хэлтэс, тасаг, хэсгийн бүтэцтэй байна.

2.2. Төв нь Цагдаагийн ерөнхий газрын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулах ба төвийн өдөр тутмын үйл ажиллагаанд Нийслэлийн цагдаагийн газар хяналт тавина. Төвийн дэргэд цагдаа, эрүүл мэнд, онцгой байдлын байгууллагын алба хаагчаас бүрдсэн зөвлөлдөх хороо ажиллаж, төвийн тайланг улирал, хагас бүтэн жилээр, шаардлагатай гэж үзвэл тухай бүр сонсон, шийдвэр гаргаж, үнэлэлт дүгнэлт өгнө.

2.3. Төвийн бүтэц, орон тоог Хууль зүй, Эрүүл мэнд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын хамтарсан тушаалаар тогтоож, төвийн даргыг Цагдаагийн ерөнхий газрын дарга томилж, чөлөөлнө.

2.4. Төвийн цагдаагийн офицер бүрэлдэхүүний томилолт, цол олгох саналыг Нийслэлийн цагдаагийн газраар уламжлан Цагдаагийн ерөнхий газарт, Онцгой байдлын офицер бүрэлдэхүүний томилолт, цол олгох саналыг Онцгой байдлын ерөнхий газарт тус тус танилцуулж шийдвэрлүүлнэ.

2.5. Эмнэлгийн мэргэжлийн алба хаагчдыг Эрүүл мэндийн яамны холбогдох албан тушаалтантай зөвшилцөн төвийн дарга томилж, чөлөөлнө.

2.6. Төвийн алба хаагчид нь албан тушаалын зэрэглэл, ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн дээд байгууллагын шийдвэрээр олгосон цол, ялгах тэмдэг бүхий дүрэмт хувцас хэрэглэнэ.

2.7. Төвийн даргын дэргэд байгууллагын ойрын болон хэтийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах, даргын шийдвэрийг бодитой гаргахад хяналт тавих туслах үүрэг бүхий зөвлөлтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг байгууллагын дотоод журмаар тогтооно.

2.8. Төвийн даргын эзгүйд дэд дарга төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

2.9. Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг дотоод журам, хэтийн болон жил, улирлын ажлын төлөвлөгөө, ерөнхий менежерийн, алба хаагчдын үр дүнгийн гэрээ, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтын дагуу явуулна.

Гурав. Төвийн үндсэн чиглэл, эрх үүрэг

3.1. Төвийн үндсэн чиглэл

3.1.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх, гамшиг осол, гал түймрийн аюулаас хамгаалах, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох, эмнэлгийн яаралтай тусламжийн дуудлагаар үйлчлэх үндсэн үйл ажиллагаанд холбоо, мэдээлэл, шуурхай удирдлага, зохицуулалтаар ханган, хяналт тавьж, мэдээ, мэдээллийг боловсруулах, дээд шатны байгууллага, албан тушаалтныг шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

3.1.2. Томоохон хэмжээний гамшиг осол, гал түймэр, газар хөдлөлт, хүн малын гоц халдварт өвчин, техникийн осол, объектын болон ойн түймэр, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед Улсын болон Нийслэлийн Онцгой комиссыг шаардлагатай мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлнэ.

3.1.3. Гэмт хэрэг, зөрчил, гамшиг осол, гал түймрийн аюулаас хамгаалах, аврах, эмнэлгийн яаралтай тусламжийн дуудлагын талаарх мэдээ, мэдээллийг нэгтгэн гаргаж холбогдох албад, албан тушаалтнуудад хүргүүлэх.

3.2. Төвийн үүрэг

3.2.1. Мэдээлэл, шуурхай удирдлагын төв нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас холбоо, мэдээллийн хэрэгсэл, бусад хэлбэрээр ирүүлж буй гэмт хэрэг, зөрчлийн болон гамшиг, осол, гал түймэр, эмнэлгийн яаралтай тусламжийн талаарх мэдээллийг шуурхай хүлээн авч, хийгдвэл зохих хойшлуулшгүй ажиллагааг зохион байгуулах, төрөл мэргэжлийн албадын үйл ажиллагааг холбон шуурхай удирдлагаар хангах.

3.2.2. Төв нь Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн газар, Онцгой байдлын ерөнхий газар, Яаралтай тусламжийн төвийн удирдлагаас улс, нийслэл хотын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гамшиг осол, гал түймрийн аюулаас хамгаалах, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох, эмнэлгийн яаралтай тусламжийн дуудлагаар үйлчлэх үндсэн үйл ажиллагаанд холбоо, мэдээлэл, хяналт, шуурхай удирдлага, зохицуулалтын чиглэлээр дэмжлэг үзүүлэх.

3.2.3. Төв нь хяналтын дэлгэц, камерын систем, дотуур, гадуур телефон аппарат, тоон, аналог радио станцын үйл ажиллагааг 24 цагийн турш тасралтгүй зохион байгуулах.

3.2.4. Нийслэлийн цагдаагийн газар болон 9 дүүргийн цагдаагийн хэлтэс, Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газрын холбоо, мэдээлэл, хяналтын тоног төхөөрөмж, /дахин дамжуулах, суурин, автомашины, гар станцууд/ компьютер техник хэрэгсэл, сервер, дотоод, гадаад сүлжээ, програм хангамжийн өдөр тутмын үйлчилгээ, засварыг хариуцан явуулж албаны бэлэн байдал, шуурхай ажиллагааг тасралтгүй хангаж, хяналт тавьж ажиллах.

3.2.5. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх, гамшиг осол, гал түймрийн аюулаас хамгаалах, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх хүн, хүч хэрэгслийн болон хүлээн авсан дуудлагын талаарх шуурхай ба хугацаат мэдээллийг дээд байгууллага, албан тушаалтанд зохих журмын дагуу хүргүүлэх.

3.2.6. Байгууллагын хэмжээнд эрхэм зорилго, хэтийн /бизнес/ төлөвлөөтэй ажиллан, сахилга, дэг журам, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулж, ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих.

3.2.7. Монгол Улсын хууль тогтоомж, дээд байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж, үйл ажиллагааны тайлан гаргах.

3.2.8. Төвийн алба хаагчдын сахилга, ёс зүй, хариуцлага, мэргэжлийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж давтан сургах, гадаадын ижил мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага судлуулах.

3.3. Төвийн эрх

3.3.1. Батлагдсан төсөв, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу эзэмшиж, захиран зарцуулах.

3.3.2. Төвийн алба хаагчдаар хууль тогтоомж, дээд шатны байгууллагуудын шийдвэр, тушаал, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, буруутай үйл ажиллагаанд нь зохих хууль, дүрэм зааврын дагуу хариуцлага хүлээлгэх.

3.3.3. Ажлын зайлшгүй шаардлагаар баримт бичиг, тодорхойлолт, тайлан тооцоо судалгааг тогтоосон журмын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах.

3.3.4. Байгууллагын үйл ажиллагааны талаар эмхтгэл, гарын авлага, зөвлөмжийг хэвлэн нийтлүүлэх.

3.3.5. Байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, техникийн шинэчлэл хийх төсөл, хөтөлбөр боловсруулан танилцуулах.

Дөрөв. Төвийн даргын эрх, үүрэг

4.1. Төвийн дарга дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

4.1.1. Тус төвийн дарга нь Нийслэлийн цагдаагийн газрын даргын зөвлөлийн гишүүн байна.

4.1.2. Төвийн нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцах, төлөөлөх, гэрээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах.

4.1.3. Төвийн дарга батлагдсан бүтэц, орон тоонд багтаан:

-цагдаагийн офицер бүрэлдэхүүний томиллолт, цолны асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжлан хүргүүлж шийдвэрлүүлэх.

-Цагдаагийн ахлагч, төрийн үйлчилгээний ба гэрээт алба хаагчдыг өөрийн тушаалаар ажилд томилж, чөлөөлнө.

4.1.4. Эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, сахилга, дэг журмыг сахиулж, ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, байгууллагын байнгын, тасралтгүй, шуурхай үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангана.

4.1.5. Холбогдох байгууллага, албан тушаалтныг мэдээ, мэдээллээр хангах.

4.1.6. Иргэд, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авах.

4.1.7. Төвийн ажилтан, алба хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

4.1.8. Төвийн нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, түүний биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ажлын уялдаа холбоог хангах.

4.1.9. Холбогдох хууль тогтоомж, дотоод журмын дагуу ажилтнуудын ажлын үр дүнг харгалзан шагнал урамшуулал болон сахилгын шийтгэл оногдуулах, шагналд зохих журмын дагуу тодорхойлох.

4.1.10. “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгасан бүтээгдэхүүнийг нэг бүрчлэн нийлүүлэн төсвийг зарцуулах.

4.1.11. Төвийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хөгжлийн хэтийн төлөв, чиг хандлагын талаар бодлого, төсөл боловсруулж холбогдох дээд байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

4.1.12. Хууль, тогтоомж, дүрэм журмаар олгогдсон бусад эрхийг эдэлнэ.

Тав. Хариуцлага

5.1. Төвийн дарга, алба хаагчид нь бүтээгдэхүүн нийлүүлэх ажлын төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Зургаа. Бусад

6.1. Энэхүү дүрэмд Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

6.2. Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР